



Хэмжигдэхүүн

Тэгш өнцөгт параллелепипедийн
гадаргуун талбай, эзэлхүүн /7.9гд/

VII анги
Математик

Сурагчийн нэр Анги

Бодлого 1

Болдын зурсан тэгш өнцөгтийн урт 6.3 см, өргөн 5 см, харин Сувд түүнийхээс уртыг нь 3 дахин богино, өргөн нь ижил байхаар зурав.

1. Сувдын зурсан тэгш өнцөгтийн талбайн хэмжээ байна.

22.6

31.5

10.5

1. Сувдын зурсан тэгш өнцөгтийн талбай Болдынхоос ... дахин байна.

Бодлого 2

Нэгжийг өгсөн нэгжид шилжүүл.

$$0.5\text{га} = \dots \text{м}^2$$

$$4\text{ар} = \dots \text{м}^2$$

$$2\text{км}^2 = \dots \text{м}^2$$

$$2000\text{м}^2 = \dots \text{ар}$$

$$1\text{га} = 100\text{м} \times 100\text{м} = 10000\text{м}^2$$

$$1\text{ар} = 10\text{м} \times 10\text{м} = 100\text{м}^2$$

$$1\text{км}^2 = 100\text{га}$$

Бодлого 3

Тэгш өнцөгт параллелепипедийн урт 15 см, өргөн нь 6 см, өндөр нь 7 см бол түүний эзэлхүүн ба гадаргуун талбайг тооцоолоорой.

$$V = \dots \dots \text{см}^3$$

$$S = \dots \dots \text{см}^2$$

474

630



Бодлого 4

Урт нь 15м, өргөн нь 9м, өндөр нь 3м байшинг дээш 6м сунган давхарлажээ.

1. Анхны байшингийн эзэлхүүнийг ол.
2. Өндрийг сунгахад эзэлхүүн хэрхэн өөрчлөгдөх вэ?
3. Сунган давхарласан байшингийн эзэлхүүнийг олоорой.
4. Анхны болон давхарласан байшингийн гадна ханын талбайг тооцоолоорой.
5. Ханын талбай хэрхэн өөрчлөгдсөн бэ?

Бодолт

$$1. V = 15 \times 9 \times \dots = \dots \text{ м}^3$$

2. Өндөр ... м болж өөрчлөгдсөн тул байшингийн эзэлхүүн

$$3. V = 15 \times 9 \times \dots = \dots \text{ м}^3$$

$$4. S = 2 \times 3 \times (15 + \dots) = \dots \text{ м}^2$$

432

$$S = 2 \times \dots \times (15 + \dots) = \dots \text{ м}^2$$

144

5. Ханын талбай дахин



Бодлого 5

Сурагчид урт нь 20 см, өргөн нь 12 см, өндөр нь 6 см байх хөөсөнцөрийн уртын $\frac{3}{4}$ хэсгээр нь зүсэн 2 хэсэг болгожээ.

1. 2 жижиг хэсэг ямар биет вэ?
2. Анхны хөөсөнцөрийн эзэлхүүнийг ол.
3. Хуваалтаар үүссэн 2 хэсгүүдийн эзэлхүүн тэнцүү байж болох уу?
4. 2 жижиг хэсэг тус бүрийн эзэлхүүнийг олоорой.
5. Хуваалтын жижиг хэсгүүдийн эзэлхүүн тус бүрийг анхны хөөсөнцөрийн эзэлхүүнд харьцуулаарай.
6. Анхны болон 2 жижиг хэсгийн гадаргуун талбайг ол.
7. Гадаргуун талбай уртаас хамааран хэрхэн өөрчлөгдсөн бэ?

Бодолт



1. Үүссэн 2 жижиг хэсэг байна.

куб

квадрат

параллелепипед

2. $V = \dots \dots \text{м}^3$
3. 2 хэсгийн өргөн, өндөр нь, урт нь учраас эзэлхүүн нь байна.

$$4. V_1 = \dots \dots \text{м}^3 \quad V_2 = \dots \dots \text{м}^3$$

$$5. \frac{V_1}{V} = \dots, \quad \frac{V_2}{V} = \dots$$

$$\frac{3}{4}$$

$$\frac{1}{4}$$

$$6. S = \dots \dots \text{м}^2 \quad S_1 = \dots \dots \text{м}^2 \quad S_2 = \dots \dots \text{м}^2$$

7. Урт нь өөрчлөгдөхөд гадаргуун талбай



Бодлого 6

Аквариумын суурь нь $60\text{см} \times 30\text{см}$, өндөр нь 40см байв.

а. Аквариумыг хийхэд хэдэн

сантиметр квадрат шил орсон бэ?

б. Аквариумд хэдэн литр ус хийхэд дүүрэх вэ?

в. Хоосон аквариум 12кг бол дүүрэн устай үеийн жинг ол.

г. Аквариумд байсан усны хагасыг $40\text{см} \times 30\text{см}$ суурьтай өөр аквариум руу юүлэхэд усны түвшин ирмэгээс нь 10см доор байв. Энэ аквариумын өндрийг ол.

**Бодолт**

а.....

.....

б.....

.....

в.....

.....

г.....

.....

$$1\text{дм}^3 = 1\text{л}$$
$$1\text{л ус} \approx 1\text{кг}$$

